



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Г “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны Г  
зуучлагч /брокер/-ийн үйлчилгээний шимтгэл,  
хураамжийн хэмжээ”-г тогтоох тухай

Биржийн зохицуулах зөвлөлийн Ажлын албаны 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 01/13, Монголын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн холбооны 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 13/42, Ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгчдийн холбооны 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтүүдийг үндэслэн Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-уудад бизнесийн гарааны ижил боломж олгох, цаашдын санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйлчилгээний шимтгэлийн хэмжээг арилжааны хэлцлийн нийт дүнгийн 1.0 хувиас доошгүй байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг 2013 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /ХААБ/-дын удирдлагад үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000320